



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 4/119

Улаанбаатар хот

Хүн, малын гоц халдварт болон тарваган
таксал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Тарваган тахал өвчиний хяналт, сэргийлэлтийн заавар" А/160 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Хүн, малын гоц халдварт болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/948 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Байгалийн голомтот тарваган тахал болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл эрчимжүүлэн ажилласугай.

2. Байгалийн голомтот хүн, мал амьтны гоц халдварт болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, тарваган тахал өвчнөөс сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг гуравдугаар, үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Хүн, мал амьтны гоц халдварт өвчин, тарваган тахал өвчиний сэжигтэй дуудлага хүлээн авах, голомтод ажиллах бэлэн байдлыг хангах, сургалт, сурталчилгааг өргөжүүлэн, дүүргүүдийн эрүүл мэндийн төвийг мэргэжил, арга зүйгээр ханган, хамтран ажиллахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв /М.Мөнгөнцэцэг/-д үүрэг болгосугай.

4. Хүн, мал амьтны гоц халдварт өвчин, тарваган тахал өвчиний халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчиний хэлтэс (З.Болормаа)-т, хяналт шалгалт зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хяналтын хэлтэс (М.Мөнхгэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

5. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга наарт даалгах нь:

5.1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 160 дугаар тушаалаар батлагдсан "Тарваган тахал өвчиний хариу арга хэмжээний заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах,

5.2. Тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай дуудлагын багийн гишүүдийн бэлэн байдлыг хангах, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй дуудлагад явуулж хэвших,

5.3. Эмнэлгийн тусгаарлах өрөөний нэн шаардлагатай эм, оношлуур, халдвартгүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж, бэлэн байдлыг хангах,

5.4. Эмнэлэг дотор халдварт гарсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээг холбогдох журам, зааврын дагуу төлөвлөх, зохион байгуулах, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах,

5.5. Тарваган тахлын сэжигтэй өвчтөн ирсэн үед тусгаарлах өрөөнд тусгаарлан, нарийн мэргэжлийн эмч нар оношиг тогтоож, өвчтөнийг эмнэлэг дамжуулан явуулахгүй байх, яаралтай мэдээлэх арга зүйд сургах,

5.6. Тарваган тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед нийслэлийн Эрүүл мэндийн газар, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвд 30 минутаас 2 цагийн дотор яаралтай мэдээлж, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, эрсдлийн зэргийг тогтоон, гарааны арга хэмжээг авч, голомтын хариу арга хэмжээг үйл явдлын тэргүүлэгч байгууллагатай хамтран зохион байгуулах,

5.7. Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг оношлох, мэдээлэх, өвчтөнөөс лабораторийн сорьц авах, савлах, тээвэрлэх, тархвар судлал, тандалтын хариу арга хэмжээ авах, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж тайлах арга зүй, сэтгэл зүйн чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийг дадлагажуулан сургах,

5.8. Хүн амд тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэн, гарын авлага, теле хичээлийг ΘЭМТ-үүдэд өгч мэдээллийг хүртээмжтэйгээр иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах,

5.9. Өндөр халуурах, ханиалгах, амьсгаадах, булчирхай цочих, суулгах зэрэг шинж тэмдэгтэй өвчтнөөс тархвар судлалын асуумж судалгааг заавал тодруулж авч хэвшүүлэх,

5.10. Тархвар судлалын холбогдол бүхий эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрийгөө яаралтай тусгаарлах, харьяа эрүүл мэндийн байгууллагад зөвхөн утсаар дуудлага өгөх талаар иргэдэд олон нийтэд мэдлэг олгох,

5.11. Хэрэгжүүлж буй ажлын явцын талаарх илтгэх хуудсыг 14 хоног тутамд пүрэв гарагийн 14:00 цагт багтаан batarsuh2230@gmail.com цахим хаягаар ирүүлэх.

6. Харьяа эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулсан ажлын нэгдсэн тайланг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэст цаасан болон цахим хэлбэрээр (batarsuh2230@gmail.com) ирүүлэхийг үүрэг болгосугай.

7. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт, тандалтын үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах 1'075'500 (нэг сая далан таван мянга таван зуу) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Р.Дулмаа)-т зөвшөөрсүгэй.

8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т даалгасугай.



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

З.Болормаа Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтсийн
дарга

Гишүүд:

А.Ербахыт ДОХ, ХДХВ, БЗДХ, гепатит, сүрьеэ, бэлгийн замын
халдварт өвчний асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Ц.Бүрэнжаргал Дархлаажуулалт, улирлын томуу, томуу төст өвчин,
тарилгат өвчний тусlamж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

Б.Очмаа Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын
байцаагч

Б.Гандолгор Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын
байцаагч

Л.Мөнхсаруул Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын
байцаагч

Харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга нар

Г.Мяасурэн Жолооч

Н.Одбаяр Жолооч

Нарийн бичиг:

Б.Баатарсүх Зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт,
сэргийлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын ...-ны өдрийн
тушаалын хоёрдугаар хавсралт



**"ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ"
ЧИГЛЭЛЭЭР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага	Хүрэх түвшин
1	Тарваган тахлын өвчнөөс сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр гарсан тушаал, захирамж, албан бичгийг цаг хугацаанд нь хургуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	VIII.15-X.15	НЭӨСТ ЗӨСҮТ ХӨСҮТ ЭМЯ	Мэдээллийг тогтмол хургуулж, мэргэжил арга зүйгээр хангасан байна.
2	Тарваган тахлын хариу арга хэмжээний бэлэн байдлын неөцийг /хамгаалах хувцас хэрэгсэл, халдвартгуйжуулэлтийн бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл/ бурдуулэх, нөхөн хангах	VIII.15-VIII.31	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Бэлэн байдал хангагдсан байна.
3	Тарваган тахал болон бусад зоонозын халдварт өвчний үеийн хариу арга хэмжээний бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж хургуулэх	VIII.15-X.15	Ажлын хэсэг	Дэмжлэгт хяналт хийгдэж, зөвлөмж гарсан байна.
4	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сонор сээрэмжтэй байж, болзошгүй сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, тархвар судалын холбогдлыг тогтоох асуумж авах, ялган оношлогоо, эмчилгээ, тандалт, халдварын сэргийлэлт, хяналт, хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж тайлах арга зүй, сэтгэл зүйн чиглэлээр сургалт хийж дадлагажуулах	VIII.15-X.15	ЗӨСҮТ НЭӨСТ ХЭМБ	Сургалт хийгдэж, мэдлэг ур чадвар дээшилсэн байна.
5	ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын есдүгээр хавсралт "Тусгаарлан сэргийлэлтийн заавар"-ын 1.7-д заасан тусгаарлах өреөг бэлтгэж, бэлэн байдлыг хангах, сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай дуудлагын багийн гишүүдийн бэлэн байдлыг хангах, хамгаалах хувцас хэрэгслийн байнгын неөктэй дуудлагад явуулж хэвших	VIII.15-X.15	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Бэлэн байдал хангаж, өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.
6	Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт суртачилгааны ажлыг эрчимжүүлж, хэвлэл мэдээллээр сурталчлах,	VIII.15-X.15	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Мэдээлэл сургалт сургачилгаа эрчимжиж, эмнэлгийн тусламж

	гарын авлага, цахим хичээлийг дуурэг, ΘЭМТ-үүдэд хүргэх			үйлчилгээ сайжирна.
7	Эмнэлзүйн төстэй шинж тэмдэг илэрсэн тохиолдол бүрээс тархвар судлалын асуумж, судалгааг нарийвчлан авах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Тогтмол	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлж, хариу арга хэмжээ авч ажиллана.
8	Сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед 2 цагийн дотор ЗӨСҮТ, ХӨСҮТ-Д яаралтай мэдээлж, эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийн зэрэгт тохирсон голомтын хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах	VIII.15-X.15	ЗӨСҮТ, НЗӨСТ, Харьяа эрүүл мэндийн байгууллага	Голомтын хариу арга хэмжээг шуурхай авч, өвчлөлийг таслан зогсоно.
9	Тархвар судлалын холбогдол бүхий эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрийгөө яаралтай тусгаарлах, харьяа эрүүл мэндийн байгууллагад зөвхөн утсаар /70282853-ЗӨСҮТ, 70210316-НЗӨСТ/ дуудлага өгөх талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх	VIII.15-X.15	ЗӨСҮТ, НЗӨСТ, Харьяа эрүүл мэндийн байгууллага	Халдварын тархалтыг зогсоно.
10	Цахим тандалт хийж, залруулга мэдээллийг тухай бүр хийж ажиллах	VIII.15-X.15	ХЭМБ-ууд	Иргэдийн мэдлэг дээшилсэн байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн
1119 тушаалын гуравдугаар хавсралт

9023070010
9077456-6-ОБТ22555

**ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

№	Овог нэр	Албан тушаал	Хугацаа	Байршил	Хамтран ажиллах байгууллага
1	А.Ербахыт	Ахлах мэргэжилтэн	VIII.18	Багануур Багахангай Налайх дүүргийн АТШНТовчоо	НМЭГ, НЦУГ, НОБГ
2	Б.Баатарсүх	Ахлах мэргэжилтэн	IX.01		
3	Б.Очмаа	Улсын байцаагч	IX.15		
4	Ц.Бүрэнжаргал	Мэргэжилтэн	IX.29		
5	Б.Гандолгор	Улсын байцаагч	X.06		

**ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРОХ ХУВААРЬ**

№	Овог нэр	Албан тушаал	Хугацаа	Байршил	Зохион байгуулах байгууллага
1	Б.Очмаа	Улсын байцаагч	VIII.17, 31, IX.14, 28, X.05	Багануур Багахангай Налайх дүүргийн АТШНТовчоо	ЗЦГ
2	А.Ербахыт	Ахлах мэргэжилтэн	VIII.19, IX.02, 16, 30, X.07		НМЭГ
3	Б.Гандолгор	Улсын байцаагч	VIII.20, IX.03, 17, X.01, 15		ЗЭСҮТ
4	Т.Мөнхсаруул	Улсын байцаагч	VIII.21, IX.04, 18, X.02,		НОБГ
5	Б.Баатарсүх	Ахлах мэргэжилтэн	VIII.22, IX.05, 19, X.03,		НМЭГ

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 7-ны өдрийн
тушаалын деревдүгээр хавсралт

9029070010
9077456 & СБТ22533

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ, ТАНДАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Шатахууны зардал /төгрөг/
1	Хяналт шалгалт явуулж буй ажлын хэсгүүдэд хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалт хийхэд зарцуулах зардал	A-92 литр	1'075'500
2	Дэмжлэгт хяналт хийхэд зарцуулах шатахууны зардал		